



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/13

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а” дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл /Ховд, Дарви, Дөргөн, Зэрэг, Жаргалант, Цэцэг, Чандмань сум/-н ажлуудыг ашиглагч, иргэнээс гаргасан гомдлын дагуу хийсэн ажлын чанар стандартыг дахин нягтлан шалгаж дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Жаргалсайхан	- Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	
Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Б.Гантулга	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Ц.Сувдаа	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Д.Эрдэнэдорж	- Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр худалдаа үйлчилгээний албаны дарга

Б.Бурмаа

-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

-Холбогдох сумдын Засаг даргын Тамгын газрын төлөөлөл

Нарийн бичгийн дарга

Л.Батгэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Дээрх ажлуудыг зураг, төсөв, стандартын дагуу хуулийн хүрээнд гүйцэтгэсэн эсэхэд нягтлан шалгаж дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Жаргалсайхан/- д даалгасугай.

3. Дээрх ажлуудад шалгалт хийхтэй холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ